

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 08 дугаар сарын 16

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хэрэгжилтийн хувь
Үүрэг, даалгавар ЗУРГАА: Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, боловсролын салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудыг дүүрэг тус бүрээр Нийслэлийн Удирдах ажилтнуудын Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах.				
1	Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил дүүргийн хэмжээнд 90 хувьтай байна. ✓ Дүүргийн 4-р хорооны 5 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын ажил 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан гэрээгээр 2024 оны 8 дугаар сард ажил бүрэн дуусах байсан. Өргөтгөлийн барилгын санхүүжилтээс 2024 онд орж ирэх санхүүжилтийн үлдэгдэл 65%-ийг 2025 оны төсөвт суулгахаар төлөвлөсөн байсныг өөрчлөн 2024 онд олгож одоо барилгын ажил 98%-тай хэвийн явагдаж байна. ✓ 8-р хорооны 640 хүүхдийн суудал бүхий сургууль: 2024 оны 4 сараас барилгын ажил эхэлж хэвийн явагдаж байна. Суурийн угсралтын ажил, гадна цэвэр бохир усны оруулга шугам хийгдэж дууссан. Барилгын ажлын явц 20%-тай байна. ✓ 12-р хороонд шинээр баригдаж байгаа 144 дүгээр бага сургууль, 276 дугаар цэцэрлэгийн цогцолбор барилгын ажлын явц 95% байна. 2023 оны 08 дугаар сарын 30-нд комисс ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авах шийдвэр гарсан боловч үлдсэн ажлаа гүйцэтгэхгүй байгаа тул гэрээг цуцалсан. НЗД-ын А/547 дугаар захирамжаар 218.0 сая төгрөгийн үлдсэн ажлын эрх дүүрэгт шилжин ирж Худалдан авах ажиллагааны алба тендер сонгон шалгаруулалтыг зарласан. Үлдэгдэл төсвийг дүүргийн төсвийн тодотголд тусгахаар төлөвлөсөн. ✓ 19-р хороонд баригдаж байгаа бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын дотор заслын ажил дууссан, хаалга хулдаас дутуу, халаалт, дулаан аваагүй, гадна фасад, асфальтан замын ажил, гадна цахилгааны ажил дутуу байгаа бөгөөд цонх суулгах болон дээврийн			70

	ажил хийгдсэн. Барилгын ажлын явц 80%-тай байна. 2023 оны 12 дугаар сарын 01-нд хүлээлгэж өгөх гэрээтэй байсан боловч гэрээг 2024 оны 10 дугаар сар хүртэл сунгасан. 2024 оны 04 дүгээр сараас ажил эхэлсэн. Гэрээт ажлыг 4 удаа сунгасан, ажил зогсонги удаашралтай байгаа тул Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас гэрээ цуцлуулахаар ажиллаж байна. ✓ 16-р хорооны цэцэрлэгийн гэрээг 2021 оны 11 сарын 10-ны өдөр байгуулж, барилга угсралтын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлсэн. 2022-2023 онд суурийн цутгалт, зоорь 1-2 давхрын каркас угсралтын ажил хийгдээд нэмэлт төсөвгүй тул зогссон. 2023 онд 100.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр санхүүжүүлж байсан бөгөөд 2024 онд санхүүжилт 1.963 сая.төг тавигдсан. Цутгалт, дүүргэлт бүрэн хийгдсэн. 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дуусгах гэрээтэй. Барилгын ажлын явц 50%-тай байна. ✓ 37 дугаар сургуулийн усан бассейн бүхий спорт заал: Нийт санхүүжилт 7,401,000,000 батлагдсанаас 2024 онд 2,220,300,000 батлагдсан ба тендер шалгарч шавь тавих үйл ажиллагаа хийгдэж, барилгын ажил эхлэхээр хүлээгдэж байна. ✓ 23 дугаар сургуулийн спорт заалыг буулгаж, усан бассейн бүхий спорт заал шинээр барих нийт санхүүжилт 7,400,000,000 батлагдсанаас 2024 онд 2,220,000,000 батлагдсан ба тендер шалгарч шавь тавих үйл ажиллагаа хийгдэж барилгын ажил эхлэхээр хүлээгдэж байна.			
Үүрэг, даалгавар ДОЛОО: Газрын асуудлыг шийдвэрлэсэн сургууль, цэцэрлэгийн барилгын асуудлыг шийдвэрлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах.				
2	Сургууль, цэцэрлэгийн газар чөлөөлөлтийн ажлууд шат дараатайгаар хийгдэж байна. Үүнд: ✓ 17-р хорооны 960 хүүхдийн суудал бүхий сургууль: Нийт 45 нэгж талбар өртсөнөөс 30 нэгж талбарыг бүрэн чөлөөлсөн, 10 нэгж талбарын иргэдтэй гэрээ байгуулсан, 5 нэгж талбарын иргэдтэй зөвшилцөж байна. ✓ 13-р хорооны 150 ортой тусгай хэрэгцээт хүүхдүүдийн цэцэрлэг Нийт 22 нэгж талбар өртсөнөөс 16 нэгж талбарын газрыг чөлөөлж нөхөх олговор олгосон, 1 нэгж талбар татгалзсан, 5 нэгж талбарын иргэдтэй зөвшилцөх шатандаа явж байна. Нэмж 3 нэгж талбарыг чөлөөлөх шаардлагатай. . ✓ 23-р хорооны 150 ортой хүүхдийн цэцэрлэг:			70

	Нийт 8 нэгж талбар өртсөн. Газар чөлөөлөлтийн нөхөх олговор олгох тухай Чингэлтэй дүүргийн Засаг даргын А/183 дугаар захирамжаар нөхөх олговрыг олгож, газар чөлөөлөлтийг хийн дуусаж байна. Нийслэлийн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан. ✓ 117 дугаар сургуулийн авто зогсоолын зориулалтаар 2 нэгж талбарт газар чөлөөлөлт хийсэн.			
Үүрэг, даалгавар НАЙМ: Нийслэлийн хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлагдаад амжилтгүй болсон тендерүүдийн шалтгаан нөхцөл болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулах.				
3	Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолын дагуу төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2023-2024 он дамжин санхүүжих болон 2024 онд хэрэгжих нийт 166 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс 28 төсөл арга хэмжээг нийт гурав ба түүнээс дээш удаа зарлахад нэг ч оролцогч тендер ирүүлээгүй тул захиалагчид ажлын даалгавар, тоо хэмжээг хянуулахаар албан бичиг явуулсан. Захиалагч байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирсэн төсөл арга хэмжээг өдөрт нь багтаан худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn болон www.chingeltei.gov.mn цахим системээр дамжуулан ил тод нээлттэй зарлан ажиллаж байна. Дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 17 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээг өөрчлөхөөр хянаж байна. 3 төсөл, арга хэмжээг хасахаар шийдвэрлэсэн. Үүнд: 1. Жигжидийн амны уулзварын засварын ажил 2. Насан туршийн Суралцахуйн төвд шаардлагатай тоног төхөөрөмж 3. “Нийтлэг үйлчилгээний газар” ОНӨТҮГ-т машин механизм худалдаж авах 2024 оны 08 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд холбогдох хэлтэс, албад болон хороодын Засаг дарга нартай уулзалт хийж, худалдан авах ажиллагаа амжилтгүй болж байгаа ажлуудыг танилцуулж, худалдан авах ажиллагаанд оролцогч оролцохгүй байгаа шалтгааныг хэлэлцсэн. Уулзалтаар оролцогчгүй 26 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ их, төсөв магадлагдаагүй тул ажлын тоо хэмжээг багасгаж өөрчлөх шаардлагатай гэж шийдвэрлэсэн. Нийт 21 төсөл, арга хэмжээний тоо хэмжээг хянаж өөрчлөхөөр зургийн автортой уулзалт хийж, зөвлөлдөж ажиллаж байна.			70
Үүрэг, даалгавар АРВАН ХОЁР: Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд инженерийн шугам сүлжээ, авто зам, тохижилт, ногоон байгууламжийн ажлуудыг газар дээр явж хянаж шалгаж, чанар стандартыг хангуулах.				

4	Дүүргийн Засаг даргын 2024 оны А/227 дугаар захирамжаар 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулагдан 12 салбарын 128 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж, 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар хэрэгжилт 85%-тай байна. Тус захирамжийн дагуу өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын явцын тайлан, мэдээ, хувийг тооцож сар бүрийн 20-ны өдрийн дотор Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст албан бичиг болон файлаар ирүүлэхийг үүрэг болгон ажиллаж байна. “Чингэлтэй Тохижилт үйлчилгээ” ХХК нь 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар бэлтгэл ажлыг 100% ханган 1500тн давс, 1500тн бодисыг бүрэн татан авч нөөцөлсөн байна. “Найши трейд” ХХК өөрийн хариуцсан зам талбай болон авто замын зорчих хэсэгт халтиргаа гулгаа үүсэхээс сэргийлэх зорилгоор өөрийн хөрөнгөөр 250тн давс, 150тн тусгай зориулалтын бодис худалдан авч нөөцөлснөөс 130тн давс, 100тн тусгай зориулалтын бодисыг зарцуулж 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 120тн давс, 50тн тусгай зориулалтын бодисын үлдэгдэлтэй байна.			70
Үүрэг, даалгавар АРВАН ДӨРӨВ: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн хүрээнд хот нийтийн аж ахуйн чиг үүргийн ажлуудаа эрчимжүүлж, 8 сардаа багтааж хот нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг дүгнэх ажлыг зохион байгуулах.				
5	Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй “Дүүргийн 149 дүгээр сургуулийн урд талын авто зам, авто зогсоол, автобусны буудал” төсөл арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө дуусгах талаар төслийг хэрэгжүүлэгч “Нано экологи” ХХК-ний инженер Н.Ганзоригт мэдэгдэл хүргэсэн. Мөн дүүргийн 6 дугаар хороо, Л.Лааганы гудамж (Баянбүрдийн тойрог орчим)-ны авто замын зорчих хэсэгт 2024 оны 06 дугаар сард дулааны шугам засварын ажил хийсэн ч нөхөн сэргээлтийн ажлыг одоог хүртэл хийж гүйцэтгээгүй байгаа тул нөхөн сэргээлтийн ажлыг яаралтай хийлгэх тухай Засаг даргын Тамгын газрын даргын 3/1980 тоот албан бичгийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсэн.			30
Үүрэг, даалгавар АРВАН ТАВ: Дүүргийн удирдлагууд өөрсдийн хариуцсан нутаг дэвсгэртээ хот нийтийн аж ахуй, нийтийн эзэмшлийн гудамж зам талбай болон явган хүний зам талбайн нөхцөл байдалтай газар дээр нь явж ажиллах.				
6	Дүүргийн Засаг дарга Б.Мөнхбат, ЗДТГ болон дэргэдэх хэлтэс албадын удирдлага, зохих албан хаагчдын хамт Нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний замын нөхцөл байдалтай газар дээр нь явж танилцаж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, явган хүн зорчиход			100

	хүндрэлтэй замуудыг сайжруулж, шинэчлэн ажиллаж байна. Нийтийн эзэмшлийн авто болон явган зам талбайд дараах засварын ажлууд хийгдэж байна. -1, 4, 12, 16, 18 дугаар хороодын борооны ус тогтдог 280м2 явган зам талбай, борооны усны нөлөөгөөр суларсан, хагарал өгч бутарсан 100м2 чулуун авто замуудад засварын ажлыг Чингэлтэй Дүүргийн Тохижилт Үйлчилгээний компани хийж гүйцэтгэсэн. - 6 дугаар хороо 5 дугаар сургуулийн хажуу талын иргэд зорчих боломжгүй аж ахуйн нэгж байгууллагууд нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд зөвшөөрөлгүй шат довжоо хийж гүйцэтгэснийг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр буулгаж чөлөөлөн явган хүний зам талбайг хийж гүйцэтгэсэн. - 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах СУИС-ын баруун урд талын бетонон хашааг буулгаж, оюутан сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх орчин бий болгохоор ажиллаж байна. - 1 дүгээр хорооны 18 метр квадрат талбайд газар дор байрлах 3 куб метрийн хэмжээтэй 2 ширхэг ухаалаг хогийн савыг байршуулсан. Тус ухаалаг хогийн савыг дүүргийн бүх хороодод байршуулахаар төлөвлөн ажиллаж байна. - Барилгачдын талбайн баруун талын явган хүн зорчиход хүндрэлтэй замыг сайжруулж, шинэчлэн ажилласан.			
Үүрэг, даалгавар АРВАН ЕС: Нийслэлийн хэмжээнд газар чөлөөлөлтийн ажлыг эрчимжүүлж, газар дээр явж ажиллах бэлтгэл хангах.				
7	Монгол улсын Засгийн газраас 2024 оныг бүсчилсэн хөгжлийн жил болгон зарласан. Үүнтэй холбоотойгоор “Сэлбэ дэд төв”-ийг түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах газар чөлөөлөлтийн ажил зохион байгуулагдаж байна. Ажлын хүрээнд 1349 айлтай гэрээ байгуулж, 1270 айл нь санхүүжилтэй бүрэн аваад байна. Газар чөлөөлөлтийн ажил 76 хувьтай үргэлжилж байна. Газрын зөрчил арилгах арга хэмжээний хүрээнд 36 байршилд гарааш, хашаа, хайс буулгахаар төлөвлөгдсөний дагуу дараах ажлууд хийгдээд байна. Үүнд: 1. 9 байршилд 63 тоосгон гарааш 6 байршлын 45 тоосгон гараашийг бүрэн чөлөөлсөн. ✓ 2 дугаар хороо Сансар КАТв-н зүүн урд талд 15ш гарааш ✓ 3 дугаар хороо Алтай центрийн урд талд 4ш гарааш ✓ 4 дүгээр хороо 16/1 байрны зүүн талд 1ш гарааш /тоосгон пүтэк/ ✓ 4 дүгээр хороо 46 дугаар байрны хойд талд 4ш гарааш ✓ 4 дүгээр хороо 30А байрны баруун талд 4ш гарааш ✓ 6 дугаар хороо 61 дүгээр байрны хойд талд 17ш гарааш			70

	2. 27 байршилд 1737 метр хашаа, хайс буулгахаар төлөвлөгдсөнөөс 12 байршлын 436 метр хашаа, хайсыг чөлөөлсөн. ✓ 3 дугаар хороо, Пэйс молл худалдааны төвийн хойд талд:36 м ✓ 3 дугаар хороо, Алтай центрийн урд талд: 14 м ✓ 4 дүгээр хороо, 16/1 дүгээр байрны орон сууцны хашаа :61 м ✓ 4 дүгээр хороо, Барилга ххк-ийн хашаа.12 м ✓ 4 дүгээр хороо, Барилга ххк-ийн хашаа:2 м ✓ 5 дугаар хороо, 26 дугаар байр, оранж төвийн урд талд:28 м ✓ 5 дугаар хороо, Үлэг гүрвэлийн музейн хашаа:125 м ✓ 5 дугаар хороо, 5 дугаар байрны урд талд :4 м ✓ 5 дугаар хороо, Маргад караоке-н зүүн талд:58 м ✓ 5 дугаар хороо, 5 дугаар байрны зүүн талд:50 м ✓ 6 дугаар хороо, Рийч зочид буудал: 28 м ✓ 6 дугаар хороо, 20 дугаар байрны хойд талд18 м			
Үүрэг, даалгавар ХОРИН ГУРАВ: Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагууд ажлын уялдаагаа хангаж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллах.				
8	Дүүргийн нутаг дэвсгэрт үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх, үерийн хариу арга хэмжээний төлөвлөлт, гамшгаас хамгаалах албадын бэлтгэл, бэлэн байдал, мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор дүүргийн Онцгой комиссын “Шуурхай штаб”-ыг Чингэлтэй дүүргийн Онцгой комиссын даргын 2024 оны 02 дугаар тогтоолоор байгуулан ажиллаж байна. Мөн Нийслэлийн Онцгой комиссын орлогч даргын 2024 оны “Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлын үзлэгийн удирдамж”-ын дагуу 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Онцгой байдлын газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Г.Батмөнхөөр ахлуулсан ажлын хэсэг дүүргийн 6, 7, 8, 24 дүгээр хороодын эрсдэлтэй 4 байршилд үзлэг шалгалт хийж, заавар зөвлөмж өгч ажилласан. Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн мэдээгээр 08 дугаар сарын 09-10-нд шилжих шөнө төв болон говийн аймгуудын нутгаар, үргэлжилсэн усархаг бороо, дуу цахилгаантай аадар бороо орох тул дүүргийн шуурхай штабт 08 дугаар сарын 09-ний өдөр Онцгой байдлын хэлтсийн ахлах дэслэгч Б.Номин-Эрдэнэ, 08 дугаар сарын 10-ны өдөр ахлах дэслэгч Б.Учрал, 08 дугаар сарын 11-ний өдөр ахлах дэслэгч Ч.Мөнгөнсарнай нар үүрэг гүйцэтгэж Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабт 3 цаг тутамд илтгэл өгч ажилласан. Үүрэг гүйцэтгэх хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт үер, усны дуудлага мэдээлэл бүртгэгдээгүй.			100

	Дүүргийн нутаг дэвсгэрт үерийн эрсдэл үүссэн тохиолдолд бэлэн байдлыг хангах үүднээс 1000 шуудай элсийг “Найши трейд” ХХК-иар бэлтгүүлж бэлэн байдлыг хангасан. Мөн тус дүүргийн 1 дүгээр хороо, Улсын их дэлгүүрийн зүүн талын явган хүний гарцан дээрх шүүрт худаг бүхий ус зайлуулах шугам ажиллахгүйн улмаас борооны ус их хэмжээгээр тогтож байсан тул “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-т мэдэгдэж хагарсан шугам хоолойг засварлуулан шүүрт худаг бүхий ус зайлуулах шугамыг хэвийн ажиллагаанд оруулсан.			
Үүрэг, даалгавар ХОРИН ДӨРӨВ: Улаан бурхан өвчний урьдчилан сэргийлэх зорилгоор эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг хангах.				
9	Дүүргийн Эрүүл мэндийн төвийн удирдлага 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр шуурхай хурал зохион байгуулж тасаг, нэгжийн дарга, эрхлэгч нарт Улаан бурхан халдварт өвчний болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн бэлэн байдлыг хангах үүрэг чиглэл өгсөн. Шуурхай удирдлагын нэгжийн бүрэлдэхүүн болон, шуурхай хариу арга хэмжээний бүрэлдэхүүнийг томилгоожуулж ажил үүргийн хуваарийг баталсан. Цаг үеийн нөхцөл байдал, эмнэлэгт тулгамдаж буй асуудлуудыг яаралтай шийдвэрлэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байна. Үүнд: Дүүргийн Эрүүл мэндийн төвийн Поликлиникт 1, Хайлааст салбар амбулаторид 1, нэгдсэн эмнэлэгт 2 тусгаарлах өрөөг тус тус бэлдэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгслийг нөхөн хангаж бэлэн байдлыг хангасан. Эмнэлгийн ажилтан, албан хаагчдад нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслийн хангалтыг хийсэн. Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан Улаан бурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтад 3 ажилтан хамрагдсан. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн Халдварын сэргийлэлт хяналтын албанаас хороодын Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд цахим сургалт мэргэжил арга зүйгээр хангаж, мэдээ мэдээлэл хүргэж ажилласан. Улаан бурхан өвчний халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас, амны хаалт, халдваргүйтгэлийн бодисын нөөцийн бэлэн байдлын судалгааг гаргаж шаардлагатай худалдан авалтуудыг хийж нөөцийг бүрдүүлсэн, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг гаргасан болно. Иргэдэд зориулан цахим орчинд улаан бурхны сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байна. Дүүргийн хэмжээнд Улаан бурхан өвчний шинж тэмдэгтэй хүн одоогоор илрээгүй байна.			100

Үүрэг, даалгавар ХОРИН ТАВ: Нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчид ажлын цаг ашиглалт, гүйцэтгэл, үр дүн, сахилга хариуцлага, ёс зүйн дүрэм журмуудыг мөрдөж ажиллах.				
10	Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, батлагдсан удирдамжийн дагуу ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын гүйцэтгэлд анхаарч ажиллан, цаг ашиглалтын үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж танилцуулга, мэдээлэл өгч ажилласан. Албан хаагчдын цагийн бүртгэлийг цаг бүртгэлийн системээс татан авч, удирдлагад танилцуулан ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасантай холбоотой 7 өргөдөл, гомдол ирсэн ба холбогдох албан хаагчид сонсох ажиллагаа явуулахаар мэдэгдэх хуудас хүргүүлж, хариу тайлбарыг авч сонсох ажиллагааг хийсэн. Хорооны 5 албан хаагчид “Сануулах” сахилгын шийтгэл ногдуулж, хорооны Засаг дарга нараас 2 хүнийг цалингийн 20 хувь бууруулах арга хэмжээг авч ажилласан. Ёс зүйн болон сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган, гүйцэтгэл үр дүнг нэмэгдүүлэн тухай бүр тайлагнан ажиллаж байна.			100
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ				78%